



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/98/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.dornogovi.audit.mn Дорноговь аймаг 2021 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Аудитор: Т.Мөнхтогтох Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn</p>
---	---

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд байгууллагын Олон улсын стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДГА	Дорноговь аймаг
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1.Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2.Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3.Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4.Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5.Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6.Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3.Аудитын тайлан	14
3.1.Ерөнхий зүйл	14
3.2.Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3.Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	14
3.4.Материаллаг байдал	15
3.5.Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7.Шилэн дансны мэдээлэл	17
3.8.Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9.Аудитын илрүүлэлт	18
Залруулсан алдаа	18
Аудитын зөвлөмж	18
3.10.Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	18
4.Менежментийн захидал	19
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.02.25 № 46/253

танай _____-ны № _____-т

**ХӨВСГӨЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ц.МАРТ ТАНАА**

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>44,647,082.54</u>	<u>59,574,074.59</u>
33	АВЛАГА	4,386,556.00	7,606,182.00
335	Бусад авлага	4,386,556.00	7,606,182.00
3351	Байгууллагаас авах авлага	4,357,492.00	7,600,032.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	29,064.00	6,150.00
35	БАРАА МАТЕРИАЛ	40,260,526.54	51,967,892.59
354	Хангамжийн материал	28,683,406.54	38,911,002.59
35410	Бичиг хэргийн материал	1,004,000.00	1,256,500.00
35420	Аж ахуйн материал	14,213,317.59	20,069,252.59
35430	Сэлбэг хэрэгсэл	-	3,871,000.00
35440	Түлш, шатах тослох материал	8,095,088.95	6,975,250.00
35450	Барилгын засварын материал	1,747,000.00	1,747,000.00
35460	Хүнсний материал	26,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	3,598,000.00	4,992,000.00
35600	Мал амьтад	11,577,120.00	13,056,890.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,324,169,792.42</u>	<u>1,486,261,375.93</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,324,169,792.42	1,486,261,375.93
392	Биет хөрөнгө	1,234,582,209.16	1,394,689,625.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	635,104,438.96	658,104,438.96
39202	Хуримтлагдсан элэгдэл	(14,917,225.55)	(28,664,603.55)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	161,674,800.00	205,294,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(91,340,644.39)	(113,313,024.82)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	143,220,035.08	155,027,495.88
39206	Хуримтлагдсан элэгдэл	(113,668,417.51)	(114,687,779.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,052,178.62	54,604,866.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,752,606.96)	(23,929,035.92)
39214	Бусад үндсэн хөрөнгө	917,371,432.60	1,085,057,287.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	(431,161,781.69)	(482,804,819.66)
393	Биет бус хөрөнгө	89,587,583.26	91,571,749.94
39301	Програм хангамж	1,633,500.00	4,119,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,443,916.74)	(1,945,750.06)
39303	Бусад биет бус хөрөнгө	89,398,000.00	89,398,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,368,816,874.96</u>	<u>1,545,835,450.52</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>3,205,901.00</u>	<u>365,681.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,205,901.00	365,681.00
413	Өглөг	3,205,901.00	365,681.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	153,880.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	30,000.00
4136	Бусад өглөг	3,205,901.00	181,801.00
41361	Байгууллагад төлөх өглөг	3,205,901.00	101,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	80,801.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,365,610,973.96</u>	<u>1,545,469,769.52</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,365,610,973.96	1,545,469,769.52
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГС/ ОНС	1,405,764,735.81	1,405,764,735.81
51101	Өмч: - төрийн	1,405,764,735.81	1,405,764,735.81
512	Хуримтлагдсан үр дүн	(203,191,168.58)	(23,332,373.02)
51210	Өмнөх үеийн үр дүн	(203,191,168.58)	(199,985,267.58)
51220	Тайлант үеийн үр дүн	-	176,652,894.56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	163,037,406.73	163,037,406.73
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,368,816,874.96</u>	<u>1,545,835,450.52</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	664,293,430.00	639,652,377.85
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	232,586,100.00	280,227,405.00
120	Нийтлэг татварын бус орлого	49,800,100.00	280,227,405.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	49,800,100.00	280,227,405.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	592,000.00	500,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	49,208,100.00	279,727,405.00
122	Тусламжийн орлого	182,786,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	182,786,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	431,707,330.00	359,424,972.85
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	98,479,230.00	23,086,011.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,688,770.00	4,335,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	80,790,460.00	18,751,011.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	333,228,100.00	336,338,961.85
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	308,228,100.00	336,338,961.85
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	25,000,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	404,290,423.46	449,557,818.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	404,290,423.46	449,557,818.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	402,522,893.54	437,212,448.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,847,912.00	230,056,017.00
210101	Үндсэн цалин	203,847,912.00	230,056,017.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,403,060.08	30,442,155.71
210201	Тэтгэврийн даатгал	18,689,260.08	22,562,608.71
210202	Тэтгэмжийн даатгал	1,542,800.00	2,066,491.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,928,500.00	1,641,498.00
210204	Ажилгүйдлийн даатгал	385,700.00	379,276.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,856,800.00	3,792,282.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,777,591.00	11,636,034.14
210301	Гэрэл, цахилгаан	3,432,791.00	3,949,034.14
210302	Түлш, халаалт	4,061,600.00	7,141,000.00
210303	Цэвэр, бохир ус	283,200.00	546,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,246,351.55	28,369,913.95
210401	Бичиг хэрэг	4,822,290.00	4,417,580.00
210402	Тээвэр, шатахуун	15,600,071.05	17,279,034.95
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,984,000.00	1,531,380.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,839,990.50	2,077,894.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	351,860.00
210408	Бараа материал акалсны зардал	-	2,592,165.00
2105	Нормативт зардал	2,346,020.00	4,452,031.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	13,200.00
210502	Хоол, хүнс	2,283,100.00	4,381,031.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	62,920.00	57,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,053,290.00	590,700.00

Хөвсгөл сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	5,053,290.00	590,700.00
2107	Томилолт, зочны зардал	4,420,260.00	2,488,300.00
210702	Дотоод албан томилолт	4,420,260.00	2,488,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,909,846.00	10,230,310.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,850,646.00	8,696,660.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	237,960.00	544,940.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	273,200.00	210,333.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,600.00	19,800.00
210807	Газрын төлбөр	256,440.00	182,577.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,518,562.91	118,946,986.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,827,122.00	9,819,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	198,000.00	5,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,493,440.91	109,122,286.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,767,529.92	12,345,370.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,315,000.00	12,345,370.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,315,000.00	12,345,370.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	452,529.92	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	452,529.92	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>260,003,006.54</u>	<u>190,094,559.83</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	805,600.00	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	805,600.00	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	13,441,665.27
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	5,061,435.27
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	8,380,230.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	805,600.00	(13,441,665.27)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>260,808,606.54</u>	<u>176,652,894.56</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>409,662,976.00</u>	<u>365,604,803.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	592,000.00	500,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	592,000.00	500,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	592,000.00	500,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	592,000.00	500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	409,070,976.00	365,104,803.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	100,842,876.00	27,443,503.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,688,770.00	4,335,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	83,154,106.00	23,108,503.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	308,228,100.00	337,661,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	308,228,100.00	337,661,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>409,662,976.00</u>	<u>356,934,903.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	409,662,976.00	356,934,903.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	404,861,489.08	335,640,142.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	205,042,199.59	228,730,911.00
210101	Үндсэн цалин	205,042,199.59	223,373,711.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	5,357,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,305,299.49	30,559,131.71
210201	Тэтгэврийн даатгал	18,591,499.49	21,295,298.71
210202	Тэтгэмжийн даатгал	1,542,800.00	2,393,768.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,928,500.00	1,861,286.00
210204	Ажилгүйдлийн даатгал	385,700.00	455,880.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,856,800.00	4,552,899.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,375,240.00	13,031,283.14
210301	Гэрэл, цахилгаан	3,255,240.00	3,949,034.14
210302	Түлш, халаалт	7,818,000.00	8,536,249.00
210303	Цэвэр, бохир ус	302,000.00	546,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,264,973.00	23,596,116.00
210401	Бичиг хэрэг	3,450,800.00	4,168,480.00
210402	Тээвэр, шатахуун	17,680,653.00	16,547,126.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,484,000.00	1,560,530.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	649,520.00	1,199,980.00
2105	Нормативт зардал	200,000.00	894,560.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	894,560.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,999,471.00	5,322,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.00	200,000.00
210602	Тавилга	-	134,000.00
210604	Урсгал засвар	1,999,471.00	4,988,200.00
2107	Томилолт, зочны зардал	4,420,260.00	2,488,300.00
210702	Дотоод албан томилолт	4,420,260.00	2,488,300.00

Хөвсгөл сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,217,521.00	15,466,541.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,158,321.00	14,033,891.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	475,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	237,960.00	544,940.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	273,200.00	210,333.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,600.00	19,800.00
210807	Газрын төлбөр	256,440.00	182,577.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,036,525.00	15,551,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,838,525.00	15,332,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	198,000.00	219,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,801,486.92	21,294,760.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,551,165.00	15,383,590.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,551,165.00	15,383,590.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	452,529.92	5,911,170.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	452,529.92	1,322,338.15
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,588,832.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,797,792.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,797,792.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u><u>-</u></u>	<u><u>8,669,900.00</u></u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	8,669,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	8,669,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	8,669,900.00
222001	Тоног төхөөрөмж	-	4,009,900.00
223001	Бусад хөрөнгө	-	4,660,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u><u>-</u></u>	<u><u>(8,669,900.00)</u></u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u><u>-</u></u>	<u><u>-</u></u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,405,764,735.81	163,037,406.73	(465,059,775.12)	1,103,742,367.42
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,060,000.00	1,060,000.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,405,764,735.81	163,037,406.73	(463,999,775.12)	1,104,802,367.42
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	260,808,606.54	260,808,606.54
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,405,764,735.81	163,037,406.73	(203,191,168.58)	1,365,610,973.96
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,405,764,735.81	163,037,406.73	(203,191,168.58)	1,365,610,973.96
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	3,205,901.00	3,205,901.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,405,764,735.81	163,037,406.73	(199,985,267.58)	1,368,816,874.96
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	176,652,894.56	176,652,894.56
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,405,764,735.81	163,037,406.73	(23,332,373.02)	1,545,469,769.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	343,375,200.00	336,838,961.85	6,536,238.15	98.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	343,375,200.00	336,838,961.85	6,536,238.15	98.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	330,375,200.00	323,908,811.85	6,466,388.15	98.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,943,800.00	228,730,911.00	1,212,889.00	99.5
210101	Үндсэн цалин	224,413,800.00	223,373,711.00	1,040,089.00	99.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,530,000.00	5,357,200.00	172,800.00	96.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,892,900.00	30,559,131.71	333,768.29	98.9
210201	Тэтгэврийн даатгал	21,295,300.00	21,295,298.71	1.29	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,399,400.00	2,393,768.00	5,632.00	99.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,919,500.00	1,861,286.00	58,214.00	97.0
210204	Ажилгүйдлийн даатгал	479,800.00	455,880.00	23,920.00	95.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,798,900.00	4,552,899.00	246,001.00	94.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,040,000.00	13,031,283.14	8,716.86	99.9
210301	Гэрэл, цахилгаан	3,950,000.00	3,949,034.14	965.86	100.0
210302	Түлш, халаалт	8,539,500.00	8,536,249.00	3,251.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	550,500.00	546,000.00	4,500.00	99.2
2104	Хангамж, бараа материалын зардал	23,866,700.00	21,490,950.00	2,375,750.00	90.0
210401	Бичиг хэрэг	3,637,500.00	3,833,480.00	(195,980.00)	105.4
210402	Тээвэр, шатахуун	17,005,200.00	15,046,460.00	1,958,740.00	88.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,291,030.00	208,970.00	86.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	524,000.00	120,000.00	404,000.00	22.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200,000.00	1,199,980.00	20.00	100.0
2105	Нормативт зардал	1,200,000.00	894,560.00	305,440.00	74.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,200,000.00	894,560.00	305,440.00	74.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,924,000.00	11,912,100.00	11,900.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	5,999,900.00	100.00	100.0
210602	Тавилга	1,424,000.00	1,424,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	4,500,000.00	4,488,200.00	11,800.00	99.7
2107	Томилолт, зочны зардал	1,942,200.00	1,818,300.00	123,900.00	93.6
210702	Дотоод албан томилолт	1,942,200.00	1,818,300.00	123,900.00	93.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,345,600.00	10,252,576.00	2,093,024.00	83.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,797,000.00	8,819,926.00	1,977,074.00	81.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	475,600.00	475,000.00	600.00	99.9
210803	Даатгалын үйлчилгээ	560,000.00	544,940.00	15,060.00	97.3

Хөвсгөл сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,000.00	210,333.00	16,667.00	92.7
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	19,800.00	46,200.00	30.0
210807	Газрын төлбөр	220,000.00	182,577.00	37,423.00	83.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,220,000.00	5,219,000.00	1,000.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	220,000.00	219,000.00	1,000.00	99.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,000,000.00	12,930,150.00	69,850.00	99.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,000,000.00	12,930,150.00	69,850.00	99.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,000,000.00	12,930,150.00	69,850.00	99.5
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	343,375,200.00	336,838,961.85	6,536,238.15	98.1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	342,875,200.00	336,338,961.85	6,536,238.15	98.1
132001	Орон нутгийн төсвөөс	342,875,200.00	336,338,961.85	6,536,238.15	98.1
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	500,000.00	500,000.00	-	100.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	500,000.00	-	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	27,443,503.00	(27,443,503.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	27,443,503.00	(27,443,503.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	20,401,231.00	(20,401,231.00)
2104	Хангамж, бараа материалын зардал	-	2,105,166.00	(2,105,166.00)
210401	Бичиг хэрэг	-	335,000.00	(335,000.00)
210402	Тээвэр, шатахуун	-	1,500,666.00	(1,500,666.00)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	269,500.00	(269,500.00)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	500,000.00	(500,000.00)
210604	Урсгал засвар	-	500,000.00	(500,000.00)
2107	Томилолт, зочны зардал	-	670,000.00	(670,000.00)
210702	Дотоод албан томилолт	-	670,000.00	(670,000.00)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	5,213,965.00	(5,213,965.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	5,213,965.00	(5,213,965.00)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	11,912,100.00	(11,912,100.00)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	11,912,100.00	(11,912,100.00)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	7,042,272.00	(7,042,272.00)
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	2,453,440.00	(2,453,440.00)
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,453,440.00	(2,453,440.00)
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	4,588,832.00	(4,588,832.00)
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		4,588,832.00	(4,588,832.00)
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	27,443,503.00	(27,443,503.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	27,443,503.00	(27,443,503.00)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,335,000.00	(4,335,000.00)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	23,108,503.00	(23,108,503.00)
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Тамгын газрын дарга Ц.Март танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, түрээсийн орлогын талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 15-аас 2021 оны 02 дугаар сарын 18-ны хооронд аудитор Т.Мөнхтогтох хариуцаж хэрэгжүүлэв.

Хөвсгөл сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 6/36 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хөвсгөл сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэж төрийн үйлчилгээг хүргэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна.

Үүнд:

- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”;
- Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоол “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай”;

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хөвсгөл сумын Засаг даргын Тамгын газрын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Дорноговь аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 оны 9 дүгээр сард Хөвсгөл сумын Засаг даргын Тамгын газрын 2018-2019 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд шалгалт хийсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 225,351.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,253.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон, гүйцэтгэлийн үе шатанд 4,629.9 мянган төгрөгөөр тооцож, баталгаажууллаа.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөвсгөл сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 177,018.5 мянган төгрөгөөр буюу 12.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	4,386.5	7,606.2	3,219.7
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	40,260.5	51,967.9	11,707.4
Үндсэн хөрөнгө	1,324,169.8	1,486,261.3	162,091.5
Нийт хөрөнгө	1,368,816.8	1,545,835.4	177,018.6
Өр төлбөр	3,205.9	365.7	-2,840.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,365,610.9	1,545,469.7	179,858.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,368,816.8	1,545,835.4	177,018.6

Авлага дансны үлдэгдэл 7,606.2 мянган төгрөг болж 3,219.7 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтийн үлдэгдэл төвлөрүүлэлт, тээвэр шатахууны авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 51,967.9 мянган төгрөг болж 11,707.4 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь албан хэрэгцээний аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл, нүүрс, өвс зэргийн нөөц үүсгэснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,486,261.3 мянган төгрөг болж 162,091.5 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлууд, урсгал төсвийн худалдан авсан хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталсан 22,123.3 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Орон нутгийн орлогын, нягтлан бодох бүртгэлийн програм хангамжаар биет бус хөрөнгө нэмэгдсэн байна.

Өмнөх оны 2,840.2 мянган төгрөгийн өрийг барагдуулж, өр төлбөр дансны үлдэгдэл 365.7 мянган төгрөг болж буурсан байна. Энэ нь ХХОАТ, ҮЭ-ийн өглөг, бусад өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,545,469.8 мянган төгрөг болж 179,858.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хөвсгөл сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 24,641.0 мянган төгрөгөөр буюу 3.7 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нэмэлт санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 45,267.3 мянган төгрөгөөр буюу 11.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, бараа үйлчилгээний бусад зардал, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлууд байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 395,218.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 395,218.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 51,843.4 мянган төгрөгөөр бууруулж 343,375.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 343,375.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 342,875.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 336,338.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 500.0 мянган төгрөг, нийт 336,838.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 335,516.6 мянган төгрөгийг зарцуулж 1,322.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 336,838.9 мянган төгрөг буюу 98.1 хувьтай байна. Энэ нь хангамж бараа материалын зардал, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого

Төсвийн тухай хуульд зааснаар 2020 онд 500.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 500.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100 хувь биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	500.0	500.0	-	100
Нийт дүн	500.0	500.0	-	-

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 4,335.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 23,108.5 мянган төгрөг, нийт 27,443.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 2,105.2 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 500.0 мянган төгрөг, томилот зочны зардалд 670.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 5,213.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 11,912.1 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 2,453.4 мянган төгрөг нийт 22,854.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 4,588.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 1 мэдээлэл байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Зарим мэдээллийг мэдээлээгүй дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1, 2, 3, 6, 8, 9 дүгээр сарын нийт 105,815.7 мянган төгрөгийн урсгал санхүүжилтийг мэдээлээгүй;
- Хөрөнгө зарцуулах 13,774.6 мянган төгрөгийн 7 тушаалыг мэдээлээгүй, бусад тушаал шийдвэрийг жагсаалтаар мэдээлсэн ч шийдвэрийн хуулбарыг pdf файлаар мэдээлээгүй;
- Байгууллагын батлагдсан төсвийг огт мэдээлээгүй;
- Дараа жилийн төсвийн төсөл мэдээлэх хэсэгт өөр байгууллага буюу сумын ИТХ-ын төсвийн төслийг мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 404.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн актыг хэрэгжүүлсэн байна. Аудитаар өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	179.9	1	179.9	-	-	-
Албан шаардлага	2	15,079.7	2	15,079.7	-	-	-
Зөвлөмж	1	55,000.0	1	55,000.0	-	-	-
Нийт дүн	4	70,259.4	4	70,259.4	-	-	-

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,805.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3,463.5 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 342.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Малын нас дэвшилтийг бүртгээгүй байсныг 2,615.8 мянган төгрөгөөр залруулав.
2. Тооцооны дансаар дамжуулаагүй 847.7 мянган төгрөгийн 11 ажил гүйлгээг шууд зардлаар бүртгэсэн байсныг залруулав.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

1.1 Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 6 нэр төрлийн 101 ширхэг 176.3 сая төгрөгийн хөрөнгө байна.

1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, дансны үнэ бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү үүсэх.

1.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Ашиглах боломжтой боловч ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг үнэлж бүртгэх, шаардлага хангаагүй хөрөнгийг акталж данснаас хасах арга хэмжээ авч ажиллах.

2 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

2.1 Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт, хууль, дүрэм, журамд нийцүүлэн шинэчлээгүй байна.

2.2 Эрсдэл:

НБББББ нь холбогдох стандартын шаардлага хангаагүй байх, шинээр батлагдсан хууль, дүрэм журам, зааврыг мөрдөхгүй байх

2.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллах”, 20 дугаар зүйлийн 20.2.2-д “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль, дүрэм, журам стандартад нийцүүлэн шинэчлэх.

3 Орлогын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

2020 онд 7 иргэнтэй 8 төрлийн түрээсийн гэрээ байгуулсан. Түрээслэгч Э.Оюунцэцэг /ахуйн үйлчилгээний төвийн өрөө/ 180.0 мянган төгрөг, М.Батбаяр /ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж/ 72.0 мянган төгрөг, У.Баярцэцэг /орон сууц/ 90.0 мянган төгрөг нийт 342.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

3.2 Эрсдэл:

Гэрээгээр хүлээсэн үүрэг зөрчигдөх.

3.3 Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн өмчийн түрээсийн 2020 оны 03, 05, 08 дугаар гэрээний 5.6 “түрээсийн төлбөрийг гэрээнд заасан хуваарийн дагуу хугацаанд нь төлнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Дутуу төлсөн гэрээний төлбөрийг холбогдох түрээслэгч нараар бүрэн төлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад
талархал илэрхийлье.*

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Хөвсгөл сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021.02			ДГА-2021/98/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хөвсгөл сумын Засаг даргын Тамгын газар		мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
0	1	2	3	4	5
1	Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг шүүж үзэхэд байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 6 нэр төрлийн 101 ширхэг 176.3 сая төгрөгийн хөрөнгө байна.	-	Зөвлөмж өгөх	Дарга нягтлан бодогч	Ц.Март Д.Гүнжидмаа
2	Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2017 онд боловсруулсан ч тушаал шийдвэрээр баталгаажуулаагүй бөгөөд дахин үнэлгээ, төрийн өмчийн хөрөнгийг акталж, данснаас хасах зэрэг шинээр гарсан заавар журмын дагуу өөрчлөлт шинэчлэлт хийгдээгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Дарга нягтлан бодогч	Ц.Март Д.Гүнжидмаа
3	2020 онд 7 иргэнтэй 8 төрлийн түрээсийн гэрээ байгуулсан. Түрээслэгч Э.Оюунцэцэг /ахуйн үйлчилгээний төвийн өрөө/ 180.0 мянган төгрөг, М.Батбаяр /ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж/ 72.0 мянган төгрөг, У.Баярцэцэг /орон сууц/ 90.0 мянган төгрөг нийт 342.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.	342.0	Зөвлөмж өгөх	Дарга нягтлан бодогч	Ц.Март Д.Гүнжидмаа
4	Малын нас дэвшилтийг бүртгээгүй байна.	2,615.8	Залруулга	Дарга нягтлан бодогч	Ц.Март Д.Гүнжидмаа
5	Тооцооны дансаар дамжуулаагүй 847.7 мянган төгрөгийн 11 ажил гүйлгээг шууд зардлаар бүртгэсэн байна.	847.7	Залруулга	Дарга нягтлан бодогч	Ц.Март Д.Гүнжидмаа
ДҮН		3,805.5		-	